

**ГОВЬ ХК-ИЙН 2022 ОНЫ 3-Р УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2022 оны 09-р сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: “Говь” ХК УБГД: 9010001061 Үнэт цаасны код: MN00GOV03548 Албан ёсны хаяг: Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утасны дугаар: (+976) 7013-9977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobi.mn Веб сайт: info.gobi.mn Фейсбүүк: GobiCashmere Онлайн дэлгүүр: Монгол: gobi.mn Европ: gobicashmere.com Америк: gobicashmere.com/us Хятад: gobicashmere.cn
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	780,112,500
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн: М.Сэлэнгэ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/ Хянасан: Б.Ариунаа /Тэргүүн дэд захирал/
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
Санхүүгийн байдлын үзүүлэлт	3-р улирлын санхүүгийн нэгтгэсэн тайланг хавсаргав. /Хавсралт-1/
Орлогын тайлан	
Өмчийн өөрчлөлтийн тайлан	
Мөнгөн гүйлгээний тайлан	

2.	<i>Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны дүгнэлт</i>																			
	Эрсдэл, аудитын хорооны шийдвэрийг хамт хавсаргав. /Хавсралт-2/																			
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>																			
3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	<table border="1"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2022.09.30</th> <th>2021.09.30</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Бохир ашгийн маржин</td> <td>47%</td> <td>43%</td> </tr> <tr> <td>Цэвэр ашгийн маржин</td> <td>-13%</td> <td>-35%</td> </tr> <tr> <td>Эргэлтийн харьцаа</td> <td>1.0</td> <td>0.8</td> </tr> <tr> <td>Бараа материалын эргэц</td> <td>590</td> <td>915</td> </tr> <tr> <td>Хувьцааны нэгж үнэ /₮/</td> <td>264.72</td> <td>323.76</td> </tr> </tbody> </table>	Үзүүлэлт	2022.09.30	2021.09.30	Бохир ашгийн маржин	47%	43%	Цэвэр ашгийн маржин	-13%	-35%	Эргэлтийн харьцаа	1.0	0.8	Бараа материалын эргэц	590	915	Хувьцааны нэгж үнэ /₮/	264.72	323.76
Үзүүлэлт	2022.09.30	2021.09.30																		
Бохир ашгийн маржин	47%	43%																		
Цэвэр ашгийн маржин	-13%	-35%																		
Эргэлтийн харьцаа	1.0	0.8																		
Бараа материалын эргэц	590	915																		
Хувьцааны нэгж үнэ /₮/	264.72	323.76																		
3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>																			
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>	<ul style="list-style-type: none"> 2022 онд цар тахлын нөлөө буурч, хил нээгдсэнээр Монголд ирэх жуулчдын тоо нэмэгдсэн, мөн компани нь дотоодод зарагдаж буй бэлэн бүтээгдэхүүний үнийг 15% өсгөсөнтэй холбоотой 3-р улирлын байдлаар дотоод борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 73%-иар өсөлттэй байна. 2022 оны 3-р улирлын байдлаар Европ болон Хятад дахь охин компанийн борлуулалт өнгөрсөн оны мөн үеэс 2% болон 39%-иар өссөн бол АНУ дахь охин компанийн борлуулалт 7% буураад байна. Гадаад борлуулалтаа нэмэгдүүлэх, Говь брэндийн Монгол ноолууран бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд таниулах зорилгын хүрээнд онлайн худалдааны сувгуудаа сайжруулан олон улсад туршлагатай компаниудтай хамтран ажиллаж www.gobicashmere.com веб хуудсаа хөгжүүлэн шинэчилж 7-р сарын 22-ны өдөр ашиглалтад оруулсан. Мөн маркетинг идэвхжүүлэлтийн ажлууд дээр төвлөрч ажиллан брэнд танигдалтаа тасралтгүй нэмэгдүүлж байна. 																		
3.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</i>	Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.																		
4.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>																			

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлангийн хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

(мян.төг)

Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ	2022.09.30	2021.09.30
Холбоотой талд өгсөн санхүүжилт	105,970,741	6,838,200
Холбоотой талаас авсан санхүүжилт	105,970,741	23,933,456
Холбоотой талтай хийсэн борлуулалт	110,518	86,233
Холбоотой талаас авсан худалдан авалт	926,936	640,660
Хүүгийн орлого	-	-
Хүүгийн зардал	2,471,831	1,718,234
Түрээсийн орлого	233,351	139,659
Түрээсийн зардал	572,484	451,327


Жич: Холбоотой талууд гэдэгт Таван Богд Группийн охин компаниуд орсон болно.

5. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл

Олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.

6. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

Хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо (ширхэг)	Эзэмшлийн хувь
ТАВАН БОГД ТРЕЙД ХХК	392,640,921	50.33%
ХИДЕ ИНТЕР ХХК	265,238,300	34.00%

2022.09.30-ны байдлаар нийт 22,577 хувьцаа эзэмшигчидтэй байна. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь Таван Богд Трейд ХХК болон Хиде Интер ХХК бөгөөд тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн нэг болох Таван Богд Трейд ХХК-ийн хувьцаа эзэмшлийн хувь хагас жилийн байдлаар 50.25% байсан бол 0.08% нэмэгдэж 50.33% болсон.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага юм. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

2022 оны ээлжит хурал

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4-р сарын 23-ны өдрийн 11:00 цагт компанийн Төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” ресторанд амжилттай зохион байгуулагдав.

Хурлын ирц

Хуралд урьдчилан санал өгөх арга хэлбэрээр нийт 284,538,863 саналын эрхтэй 1,046 хувьцаа эзэмшигч, хурлын өдөр биечлэн оролцох арга хэлбэрээр 405,499,195 саналын эрхтэй 95 хувьцаа эзэмшигч буюу нийт 690,038,058 саналын эрхтэй 1,141 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц 88.45% болж бүрдэн хурал хүчин төгөлдөр явагдав.

Хурлаар танилцуулсан асуудал

1. Говь ХК-ийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайлан
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлт
3. 2021 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны ажлын тайлан

Хурлаас гарсан шийдвэр

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох тайлан илтгэлүүдийг сонсож, асуулт хариулт болон санал шүүмжлэлээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгсөн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах шийдвэрийг гаргав.

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс “Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2021 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 99.99%-ийн саналаар батлав.

Хурлын дараах тайлан

Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдээс асуулт болон санал зөвлөмжийг хүлээн авч хурлын дараа эргэн холбогдож хариу өгч ажилласан. 2022.04.26-ны өдөр ХЭХ-ын материал (122 хуудас материал, 1 ном, 1 CD)-ыг СЗХ, МХБ-д тус тус хүргүүлэн, хуулийн хугацаанд тайлагнан ажилласан.



ТУЗ-ИЙН ГИШҮҮД

2020.04.24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн 9 гишүүд (5 хараат бус, 4 ердийн гишүүн)-ийг 3 жилийн хугацаатайгаар томилсон.

ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт

ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Нандин-Эрдэнэ удаан хугацаагаар үүрэгт ажлаа биечлэн гүйцэтгэх боломжгүй болсон тул хүсэлтийг нь үндэслэн 2022 оны 09-р сарын 15-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар чөлөөлж, 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох хүртэл Д.Хүрэлбаатар-ыг хараат бус гишүүнээр түр томилохоор шийдвэрлэсэн.

ТУЗ-ийн хараат бус гишүүд



Дамбын ГЭРЭЛМАА
ТУЗ-ийн дарга, Цалин урамшууллын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор



Дамбийжавын ХҮРЭЛБААТАР
Нэр дэвшүүлэх хорооны дарга

Тэтгэвэрт гарсан



Мягмарын БАЯР
Эрсдэл, аудитын хорооны дарга

ШУТИС-ийн ҮТС-ийн Хөнгөн Үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбарын дэд профессор



Алтангэрэлийн ЖАРГАЛМАА
Эрсдэл, аудитын хорооны гишүүн

GAPE, ACCA ахлах багш, хөтөлбөрийн удирдагч



Такэши КАМБЭ
Цалин урамшууллын хорооны гишүүн

Япон улсын Asahi Life Insurance компанийн менежер

ТУЗ-ийн ердийн гишүүд




Цагаачийн БААТАРСАЙХАН
Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал



Дашдаваагийн ХУЛАН
Эрсдэл, аудитын хорооны гишүүн

Таван Богд Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч



Жавзандолгорын ОЮУНЧИМЭГ
Цалин урамшууллын хорооны гишүүн

Таван Богд Группийн Маркетингийн газрын захирал




Хидэо САВАДА

Япон улсын H.I.S компанийн Ерөнхийлөгч

	<p>ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД ТУЗ-ийн дэргэд Эрсдэл аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ТУЗ-ийн ээлжит хурал хоёр сар тутам, Эрсдэл аудитын хороо улирал тутам, Цалин урамшууллын болон Нэр дэвшүүлэх хороо хагас жил тутам ээлжит хурлаа зохион байгуулан компанийн тайлан мэдээлэлтэй танилцаж, ТУЗ-ийн гишүүдийн зүгээс өөрсдийн эрх үүргийн хүрээнд удирдлагуудад санал зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажилладаг.</p> <p>ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТУЗ-ийн зүгээс жил бүр компанийн засаглалын өөрийн үнэлгээг хийж МХБ болон өөрийн веб хуудсаар дамжуулан тайлагнадаг бөгөөд ТУЗ-ийн өөрийн үнэлгээг дотооддоо тогтмол хийн үйл ажиллагаагаа дүгнэн сайжруулдаг. Говь ХК нь сайн засаглалын туршлагаадаас суралцах, хэрэгжүүлэх, мэдээллийн нээлттэй ил тод байдлын зарчмыг баримтлан хувьцаа эзэмшигчдээ шаардлагатай мэдээллээр ханган, санал хүсэлт асуулт бүрд дор бүр нь хариу өгч ажилладаг.</p>
7.	<p><i>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</i></p>
	<p>ХУРАЛ</p> <ul style="list-style-type: none"> • Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022.04.23-ны өдөр; • ТУЗ-ийн ээлжит хурлыг 2022.01.25, 2022.02.14, 2022.03.11, 2022.04.19, 2022.08.05-ны өдрүүдэд, ээлжит бус хурлыг 2022.03.18, 2022.05.09, 2022.06.10, 2022.06.27, 2022.07.08, 2022.09.15, 2022.09.23-ны өдрүүдэд; • Нэр дэвшүүлэх хорооны ээлжит хурлыг 2022.01.17, 2022.07.27-ны өдрүүдэд, ээлжит бус хурлыг 2022.09.14-ний өдөр; • Цалин урамшууллын хорооны ээлжит хурлыг 2022.01.19, 2022.07.27-ны өдрүүдэд; • Эрсдэл, аудитын хорооны ээлжит хурлыг 2022.03.31, 2022.06.23-ны өдрүүдэд, ээлжит бус хурлыг 2022.03.03, 2022.04.19, 2022.07.19-ний өдөр тус тус зохион байгуулсан. <p>ТОГТООЛ, ШИЙДВЭР Тайлант хугацаанд нийт 34 тогтоолыг баталсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас 1 тогтоол, • ТУЗ-өөс нийт 30 тогтоол (үйл ажиллагаа өргөжүүлэх, хөрөнгө оруулалттай холбоотой 2 тогтоол, дотоод үйл ажиллагаатай холбоотой 18 тогтоол, санхүүжилттэй холбоотой 6 тогтоол, хүний нөөцтэй холбоотой 4 тогтоол) • Эрсдэл, аудитын хорооноос 3 тогтоол. <p>Мөн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлаас нийт 52 шийдвэр, 51 санал зөвлөмж, 45 үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.</p> <p>МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ 3-р улирлын байдлаар дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд СЗХ болон МХБ рүү илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> • 2021 оны Жилийн үйл ажиллагааны тайлан (монгол, англи хэлээр); • 2021 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт; • 2021 оны Компанийн засаглалын өөрийн үнэлгээний тайлан; • 2021 оны Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайлан дүгнэлт; • 2022 оны 1,2-р улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан; • 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулсан тайлан материал; • 2022 оны хагас жилээрх Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлан; <p>Мөн 2022 оны 8-р сарын 4-ний өдөр МХБ дээр хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа тавьж, хувьцаа эзэмшигч нартаа үр дүнгээ тайлагнан мэдээллээр хангасан.</p> <p>НОГДОЛ АШИГ Говь ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 2-р сарын 14-ны өдрийн №3 тоот тогтоолын дагуу компанийн 2021 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.</p>

ХУВЬЦААНЫ ХАНШ

Үзүүлэлт	2022.09.30	2021.12.31	Өсөлт, бууралт
			2022.09.30/ 2021.12.31
ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО /шир/	780,112,500	780,112,500	ЭНГИЙН хувьцаа
ХУВЬЦААНЫ ҮНЭ /төг/			
Хаалтын үнэ	264.72	325.64	-18.7%
Хамгийн их үнэ	311.50	393.62	-20.9%
Хамгийн бага үнэ	251.85	193.01	30.5%
Дундаж үнэ	279.67	270.67	3.3%
АРИЛЖААЛАГДСАН ТОО /шир/			
Хамгийн их /өдөрт/	1,234,986	4,338,588	-71.5%
Хамгийн бага /өдөрт/	392	2,768	-85.8%
Дундаж /өдөрт/	35,795	81,860	-56.3%
Нийт	6,550,441	20,464,962	-68.0%
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төг/			
Хамгийн их /өдөрт/	336,411,123	1,106,339,940	-69.6%
Хамгийн бага /өдөрт/	107,018	539,822	-80.2%
Дундаж /өдөрт/	10,085,971	22,492,411	-55.2%
Нийт	1,845,732,760	5,623,102,771	-67.2%
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төг/	206,511,381,000	254,035,834,500	-18.7%




БУСАД

- 2021 оны Жилийн үйл ажиллагааны тайлангийн агуулгыг “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасан шаардлагын дагуу бэлтгэж, улам сайжруулсан бөгөөд гадаад хөрөнгө оруулагчдад зориулан англи хэл дээр тайланг бэлтгэсэн.
- Говь ХК нь БОНЗ-ын чиглэлээр идэвхтэй ажиллахаар зорьж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор 2022.04.04-ний өдөр анх удаа “Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайлан дүгнэлт”-ийг бэлтгэн МХБ-д илгээхээс гадна компанийн цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд тайлагнасан.
- СЗХ-оос 2022.03.22-ны өдөр “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталсан бөгөөд тус шинэ кодексийн дагуу хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэн 2022.06.20-ны өдөр МХБ-рүү илгээн, олон нийтэд мэдээлсэн.


- Шинэчлэгдэн батлагдсан компанийн засаглалын кодексийн дагуу ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын агуулгаа шинэчлэн, ТУЗ-ийн ажлын албаны журмыг шинээр боловсруулан 2022.08.05-ны ТУЗ-ийн хурлаар баталсан.
- Говь ХК нь 2018.11.01-ний өдөр компанийн “Ёс зүйн дүрэм”-ийг анх баталж байсан. Түүнээс хойш 4 жилийн хугацаанд компанийн үйл ажиллагаа өргөжин тэлж буйтай холбоотой Ёс зүйн дүрэмдээ өөрчлөлт оруулан шинэчлэх шаардлага үүссэн тул 2022.08.05-ны ТУЗ-ийн хурлаар “Ёс зүйн код” нэртэйгээр агуулгыг нь шинэчлэн баталсан.
- 2022 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар Кэй Пи Эм Жи Аудит ХХК-г сонгохоор шийдвэрлэсэн.
- Мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангах зорилгын хүрээнд info.govi.mn компанийн веб хуудаст тогтмол мэдээлэл оруулан хувьцаа эзэмшигчдээ мэдээллээр ханган ажилладаг бөгөөд хувьцаа эзэмшигчдийн асуулт, санал хүсэлттэй холбоотой дуудлага, и-мэйлд дор бүр нь хариу өгч ажиллаж байна.

8. *Үйл ажиллагаатай холбоотой бусад нэмэлт мэдээлэл*

БОРЛУУЛАЛТ, ЦЭВЭР АШИГ



БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР (тэрбум төгрөг, %)



САНХҮҮГИЙН ҮР ДҮН

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021.09.30	2022.09.30		
		Гүйцэтгэл 2021Q3	Гүйцэтгэл 2022Q3	Өмнөх оноос өсөлт	
				тоо	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	<i>сая.төг</i>	77,730	104,800	27,070	35%
Үүнээс: Дотоод борлуулалт	<i>сая.төг</i>	31,733	54,997	23,265	73%
Гадаад борлуулалт	<i>сая.төг</i>	27,869	31,115	3,246	12%
Онлайн борлуулалт	<i>сая.төг</i>	18,129	18,688	559	3%
Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхэг	<i>мян.шир</i>	448	551	103	23%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	<i>сая.төг</i>	44,513	55,826	11,313	25%
НИЙТ АШИГ	<i>сая.төг</i>	33,217	48,974	15,756	47%
Бохир ашгийн хувь	<i>хувь</i>	43%	47%		9%
Үйл ажиллагааны зардал	<i>сая.төг</i>	62,712	57,613	(5,100)	-8%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ	<i>сая.төг</i>	(29,495)	(8,639)	20,856	71%
Үйл ажиллагааны ашгийн хувь	<i>хувь</i>	-38%	-8%	-	78%
Үйл ажиллагааны бус зардал	<i>сая.төг</i>	(1,821)	5,164	6,985	384%
Татварын өмнөх ашиг	<i>сая.төг</i>	(27,674)	(13,802)	13,872	50%
ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	<i>сая.төг</i>	(26,889)	(13,488)	13,401	50%
Цэвэр ашгийн хувь	<i>хувь</i>	-35%	-13%		63%
Нийт үйл ажиллагааны зардал	<i>сая.төг</i>	107,225	113,439	6,214	6%
Орлогын 1 төгрөгт ногдох зардал	<i>төгрөг</i>	1.38	1.08	(0.30)	-22%
ҮЙЛДВЭРЛЭЛ					
Сүлжмэл бүтээгдэхүүн	<i>мян.шир</i>	306	471	165	54%
Нэхмэл бүтээгдэхүүн	<i>мян.шир</i>	46	86	39	85%
Оёмол бүтээгдэхүүн	<i>мян.шир</i>	20	29	9	43%
Пальто	<i>мян.шир</i>	10	11	1	13%
Пиджак	<i>мян.шир</i>	3	5	1	43%
Ээрмэл утас	<i>тонн</i>	116	113	(4)	-3%
АЖИЛТНУУДЫН ТОО	<i>хүн</i>	1,500	1,490	(10)	-1%
Нэг ажилтанд ногдох орлого	<i>мян.төг</i>	51,820	70,336	18,516	36%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	<i>сая.төг</i>	351	2,316	1,965	560%
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<i>сая.төг</i>	308,671	306,976	(1,696)	-1%
Үүнээс: Банкны зээл	<i>сая.төг</i>	250,888	264,236	13,348	5%
НИЙТ ХӨРӨНГӨ	<i>сая.төг</i>	348,002	320,485	(27,517)	-8%
Үүнээс: Бараа материал	<i>сая.төг</i>	169,570	143,491	(26,079)	-15%
МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ	<i>сая.төг</i>	19,741	13,089	(6,652)	-34%
Үүнээс: Онлайны маркетинг	<i>сая.төг</i>	19,306	11,729	(7,577)	-39%

САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

(мян. төг)

№	Санхүүжүүлэгчийн нэр	Санхүүжилтийн хэлбэр	Жилийн хүүгийн хувь	Валют	Зээлийн үлдэгдэл 2022.09.30	Зээлийн үлдэгдэл 2021.12.31
1	Голомт Банк	Зээлийн шугам	7.20%	USD	-	9,685,920
2	Голомт Банк	Зээлийн шугам	13.50%	MNT	37,861,000	-
3	Голомт Банк	Урт хугацаат зээл	11.00%	MNT	20,000,000	-
4	Хас Банк	Зээлийн шугам	13.20%	MNT	22,610,000	10,000,000
5	Монгол Улсын Хөгжлийн Банк	Богино хугацаат зээл	11.50%	MNT	33,333,333	33,333,333
6	Худалдаа Хөгжлийн Банк (Азийн Хөгжлийн Банк)	Богино хугацаат зээл	8.00%	MNT	-	990,000
7	Монгол Улсын Хөгжлийн Банк	Богино хугацаат зээл	12.00%	MNT	42,900,000	42,900,000
8	Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк	Урт хугацаат зээл	5.25%	EUR	45,057,040	45,121,860
9	Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк	Урт хугацаат зээл	4.25%	EUR	25,746,880	51,567,840
10	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 1А)	Богино хугацаат зээл	5.30% + LIBOR	USD	6,060,036	7,251,491
11	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 1Б)	Богино хугацаат зээл	6.00% + LIBOR	USD	9,090,055	10,877,236
12	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 2)	Богино хугацаат зээл	5.30% + LIBOR	USD	10,908,066	12,431,128
13	Хаан банк	Урт хугацаат зээл	3.00%	MNT	10,000,000	-
Нийт зээлийн дүн					263,566,410	224,158,808

№	Санхүүжүүлэгчийн нэр	Санхүүжилтийн хэлбэр	Жилийн хүүгийн хувь	Валют	Зээлийн үлдэгдэл 2022.09.30	Зээлийн үлдэгдэл 2021.12.31
1	Хаалттай бонд	Богино хугацаат зээл	9.00%	MNT	670,000	10,000,000
Нийт зээлийн дүн					670,000	10,000,000

Монгол банкны хани /төг/:
 USD 3,333.02 2022-09-30 2,848.80 2021-12-31
 EUR 3,218.36 3,222.99

ХҮНИЙ НӨӨЦ



ДОТООД ЗАХ ЗЭЭЛ

Худалдан авагчдын тоо

2022 оны 3-р улирлын байдлаар худалдан авагчдын тоо 122,716 хүн байсан нь өмнөх оноос 60% өссөн бөгөөд нэг худалдан авагчийн сагсны дундаж худалдан авалт өмнөх оноос 5% өссөн үзүүлэлттэй байна.

Facebook платформын үзүүлэлт

2022 оны 3-р улирлын байдлаар Gobi Cashmere Facebook хуудсанд 5,445 like/followers шинээр нэмэгдсэн бөгөөд хүртээмжийн хувьд 15 сая, хэрэглэгчдийн оролцоо 1 саяд хүрсэн үзүүлэлттэй байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30% өсөлттэй үр дүнтэй байна.

Компанийн зүгээс Facebook хуудас дахь мэдээ мэдээллийн агуулга, давтамж, хүртээмжийг сайжруулахад анхаарч ажиллаж байна.

Жуулчдын улирлын нээлт



5-р сард хил нээсэнтэй холбоотой сүүлийн 2 жил тасраад байсан жуулчдын урсгал сэргэж, Монгол улсад ирэх жуулчдын тоо нэмэгдсээр байна. Иймд үүнийг угтан аялал жуулчлалын улирлын нээлт зохион байгуулж Аялал жуулчлалын холбоо, аяллын байгууллагууд болон хөтөч жолооч нарын 27 байгууллага 91 хүнд зориулан хүлээн авалт зохион байгуулж хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Ийнхүү энэ онд аялал жуулчлалын салбар сэргэж, Монголд ирэх жуулчдын тоо нэмэгдэж байгаа нь дотоодын борлуулалтад эерэг үр нөлөө үзүүлж байна.

3-р улирлын байдлаар дотоодын нийт борлуулалтын 24%-ийг жуулчдын борлуулалт эзэлсэн ба үүний дүнгээр нь аваад үзвэл өмнөх оноос 46 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Дэлгүүрээр нийт 22,581 жуулчин үйлчлүүлж, худалдан авалт хийсэн бөгөөд үүний 67%-ийг Солонгос улсын жуулчид эзэлж байна.

Наадам коллекцийн нээлт



Наадам коллекцийг Н.Саранцацралт зураачтай хамтран гаргасан бөгөөд энэхүү коллекцийн нээлт, загварын шоуг 7-р сарын 1-ний өдөр Галлериа Улаанбаатар салбарт зохион байгуулав.

Хэрэглэгчийн тав тухтай орчин бүрдүүлэлт



Хэрэглэгчдийн тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүрт засвар шинэчлэлийн ажлыг 2022 оны 2-р сард хийв.



Үйлдвэрийн дэргэдэх “Хими цэвэрлэгээний хүлээн авах”-ыг хуучин Outlet дэлгүүрийн байр луу шилжүүлж, үйлчилгээний зай талбайг томруулах ажлыг 2022 оны 3-р сард хийв.



Хувь захиалгын байрыг тохижуулан шинэчилж, VIP өрөөг тусгаарлан үйлчлүүлэгчид тав тухтай үйлчлүүлэх орчныг бүрдүүлэх ажлыг 2022 оны 5-р сард хийв.

ГАДААД ЗАХ ЗЭЭЛ


Харилцагчийн тоог багасган, масс захиалга өгдөг цөөн хэрэглэгчидтэй ажиллан, үйлдвэрлэлийн бүтээмж болон ашигт ажиллагааг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллаж байна. 2022 оны 3-р улирлын байдлаар 8 улсын 18 хотод 23 франчайз дэлгүүртэй үйл ажиллагаагаа явуулж байна.



ОНЛАЙН ЗАХ ЗЭЭЛ

Европ, Хойд Америкийн зах зээл

Дэлхийн зах зээлд Говь брэндийг таниулах зорилгоор маркетингийн хүрээнд олон улсын зах зээлд туршлагатай харилцагчидтай хамтран ажиллаж, брэндийн дүр төрх бүрдүүлэлт, зураг авалт, контентуудаа сайжруулан ажиллаж, АНУ-ын Half Helix агентлагаар вебсайтын дизайн хөгжүүлэлтийг хийлгэн шинэчилсэн бөгөөд 7-р сарын 22-ны өдөр цоо шинэ өнгө төрхтэйгөөр ашиглалтад оруулсан. www.gobicashmere.com



REICHERT+
COMMUNICATIONS

1-р сараас Европын зах зээлд REICHERT+ COMMUNICATIONS PR агентлагтай хамтын ажиллагааг эхлүүлж гэрээ хийсэн бөгөөд Говь брэндийн PR төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

viralspace
A SMARTLY.IO COMPANY

2-р сараас Viralspace компанитай хамтран ажиллаж эхэлсэн. Уг компани нь социал платформ дахь контентын үзүүлэлтүүд дээр тулгуурлан дата анализ хийн, Говь брэндийн контентийн чанарт нөлөөлөх зураг авалтын байршил, сурталчилгааны тайлбар, сэдэв, моделийн нүүрний хувирал гэх мэт 62 хувьсагчийг тодорхойлсон. Улмаар зураг авалтын стандарт болон зааварчилгаа гаргасан ба дата нэмэгдэхийн хэрээр тогтмол сайжруулалт хийж байна.

Үүний үр дүнд контентийн чанар сайжирч CTR буюу сурталчилгаан дээр дарж орж үзэх хувь 2021 онтой харьцуулахад 4.33 дахин нэмэгдсэн.

CHÉRIE

4-р сараас Studio Cherie-тэй хамтын ажиллагаа эхлүүлж гэрээ хийсэн бөгөөд зураг авалтын өнгө төрхөө сайжруулан веб стандарт зураг авалт болон идэвхжүүлэлтийн зураг авалт дээр хамтран ажиллаж байна.



4-р сарын 25-нд Zalando Marketplace дахь борлуулалтын сувгаа нэмж Австри улс дахь www.zalando.at дээр бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн.



6-р сараас Хойд Америкийн зах зээлд 5W PR агентлагтай хамтын ажиллагаа эхлүүлж гэрээ хийсэн. 5W-аар дамжуулан хамтарч ажиллах боломжтой брэндүүд, нөлөөлөгч нар болон сэтгүүлчидтэй холбогдон ажиллаж байна. Mens Journal болон Reader's Digest сэтгүүлүүд дээр брэндээ онцолсон нийтлэл гаргасан.



6-р сараас The Evening компанитай хамтран ажиллаж брэндийн өнгө төрх, шинэ веб дизайнтай холбоотой бүх бичвэр, зохиомжоо гаргасан.



SHOWFIELDS

9-р сарын 28-ны өдөр New York хотын төв А- бүсэд байрлах Showfields худалдааны төвд GOBI Cashmere pop-up дэлгүүр нээлтээ хийсэн. Нээлтийн үйл ажиллагаан дээр 5W x Showfields компаниуд хамтран эвентэд оролцсон. Энэхүү дэлгүүрийг 2023 оны 3-р сар хүртэл 6 сарын хугацаанд ажиллуулахаар төлөвлөж байна.



9-р сараас брэндийн органик хайлтыг сайжруулах зорилгоор Grove86 болон ICEA компаниудтай хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд аудит, шинжилгээ судалгаануудыг хийж байна.

БНХАУ-ын зах зээл



GroupM группийн охин компани болох Mediacom компанитай 2021 оны 8-р сараас эхлэн маркетингийн чиглэлээр хамтарч ажиллаж эхэлсэн бөгөөд 2022 оны 1-р сард гэрээгээ сунган хамтран ажиллаж байна.



Японы Sagawa групп компанийн БНХАУ дахь охин компани RUNBOW-тэй агуулахын үйлчилгээ авах гэрээг 6-р сард байгуулан агуулахаа Шанхай хот руу нүүлгэв. Ингэснээр хэрэглэгч нартаа захиалгыг нь илүү хурдан шуурхай, найдвартай хүргэн өгч үйлчлэх боломжийг бүрдүүлж чадсан.



SS22, FW22 коллекцуудын зураг авалтыг Хятад улсад хийн танилцуулав. Ингэснээр БНХАУ дахь хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ илүү хүргэх боломжийг нэмэгдүүлсэн.


ЗАГВАР, БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ



Шинэ коллекци

2022 онд борлуулалт, ашигт ажиллагаагаа дэмжих, хэрэглэгчдэдээ тогтмол шинэлэг бүтээгдэхүүнээр бэлэг барих зорилгоор сар бүр шинэ коллекци гаргаж, маркетингийн шинэлэг хэлбэрүүдийг ашиглах зорилт тавин ажиллаж байна.

Энэхүү зорилгынхоо хүрээнд үндсэн коллекцтой зэрэгцүүлэн цөөн тоо ширхэгтэй жижиг коллекцийн шинэ өнгө төрхтэй загварын хөгжүүлэлт дээр ажилласан. 3-р улирлын байдлаар 19 шинэ коллекци танилцуулсан бөгөөд 22 коллекцийг худалдаанд гаргасан.



Түүхий эд болон туслах материалын захиалга хийхэд цаг хугацаа болон үнийн хөөргөдөл нөлөөлж байгаа энэ үед бэлэн үлдэгдэл дээр тулгуурлаж ажиллаж байгаа нь цаг хугацааг хэмнэж, үр ашгийг нэмэгдүүлж чадсан. Цаашид брэндийн онцлогийг харуулан хэрэглэгчдийн сонирхол загварын чиг хандлагад нийцүүлэн шинэ загварын хөгжүүлэлт дээр ажиллана.



WHOLEGARMENT загварын хөгжүүлэлт

Дэлхийд анхдагч болсон WHOLEGARMENT оёдолгүй сүлжмэлийн машинууд нь оёдолгүйгээр гурван хэмжээст хэлбэрээр сүлжмэл бүтээгдэхүүн сүлжин гаргадаг бөгөөд өөр ямар ч төрлийн сүлжмэл бүтээгдэхүүнд байгаагүй дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн технологи юм. Бид 2022 онд WG оёдолгүй загварын хөгжүүлэлтийг тасралтгүй хийн, олон улсын зах зээлд хэрэглэгчдэдээ хүргэхээр капсул коллекци гарган, масс үйлдвэрлэлийг эхлүүлсэн.



Нарийн даавуу хөгжүүлэлт

Орчин үеийн загварын чиг хандлагын дагуу шинэ нэр төрлийн саатай нарийн даавууны загвар дизайн гарган хөгжүүлэлт хийгдэн ажиллаж байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Говь ХК нь тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг бизнесийн үйл ажиллагаанд нэгтгэн тасралтгүй хөгжүүлэх үүрэг амлалтыг өгсөн бөгөөд энэхүү амлалтын хүрээнд тогтвортой хөгжлийн удирдлагын дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

Бодлогын баримт бичиг

1. 2022.04.19-ний ТУЗ-ийн ээлжит хурлаар “Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт”-ыг батлан, компанийн хэмжээнд мөрдөн ажиллаж байна.
2. Байгууллагын тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17-н зорилго болон олон улсын GRI стандартад тулгуурлан тодорхойлсон.
3. 2022.04.04-ний өдөр “Байгаль орчин, Нийгэм, Засаглалын үйл ажиллагааны тайлан дүгнэлт”-ийг бэлтгэн Монголын хөрөнгийн биржид хувьцаат компаниудаас анх удаа хүргүүлсэн бөгөөд компанийн цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд тайлагнасан.
4. 2022 оны 7-р сард Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтыг Менежмент багаараа хэлэлцэн, Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулав.
5. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг Менежмент багт танилцуулсан бөгөөд одоогоор батлагдах үе шатанд явж байна.

Сургалт хөгжил

1. ТУЗ-ийн нийт гишүүдэд БОНЗ-ын ерөнхий ойлголт өгөх сургалтыг зохион байгуулав.
2. Менежмент багт 2 удаагийн тогтвортой хөгжлийн удирдлагын талаарх сургалтыг амжилттай зохион байгуулав.
3. 2022 оны 3-р улирлын байдлаар тогтвортой хөгжлийн хүрээнд 8,280 хүн/цагийн сургалтыг дотооддоо зохион байгуулав.

Мэдээллийн урсгал

1. 2022 оны 6-р сараас эхлэн гадаад, дотоод зах зээлийн хэрэглэгчдэд Тогтвортой хөгжлийн талаарх 13 мэдээллийг бэлтгэн холбогдох хэлтэс нэгжүүдэд хүргүүлсэн. /Тогтвортой хөгжлийн 3 коллекци - CashmeReborn, Organic, Wholegarment, Гурван талт төсөл, Bloomberg ярилцлага гэх мэт/

Гишүүнчлэл, хамтын ажиллагаа

1. STeP EcoLab төслийн хүрээнд Монгол улсын ноолуурын салбарын тогтвортой хөгжлийн замын зураглал – 2030 уулзалт, хэлэлцүүлэгт оролцон Говь ХК-ийн тогтвортой хөгжлийн цаашдын бодлого, хэрэгжилтийн талаар санал солилцов.
2. STeP EcoLab төслийн хүрээнд Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн MNS 6926:2021 стандартын аудитад хамрагдан 97.54%-иар үнэлэгдсэн бөгөөд салбарын хэмжээнд 1-т эрэмбэлэгдэв.
3. 2022 оны 3-р сард Тогтвортой ноос, ноолуурын эвсэлтэй хамтран SFA алтан, мөнгөн батламжийг компанийн үйл ажиллагаанд зохистой ашиглах тухай сургалтыг зохион байгуулсан.
4. 2022 оны 4-р сард Тогтвортой ноос, ноолуурын эвсэлтэй хамтран хэрэгжүүлсэн “Малчны хотноос дэлхийн брэнд” төслийн хаалтын үйл ажиллагаанд оролцон, сонирхогч талуудтай төслийн хэрэгжилт болон ач холбогдлын талаар санал солилцов.
5. 2022 оны 6-р сард STeP EcoLab төслөөс зохион байгуулсан “Тогтвортой байдлын гэрчилгээжүүлэлт - Монголын ноос, ноолуурын үнэ цэнийг нэмэгдүүлэх арга зам” сэдэвт сургалт, семинарт оролцон нээлттэй хэлэлцүүлэг хийв. Мөн энэхүү арга хэмжээний үеэр Текстилийн тогтвортой үйлдвэрлэл стандартын аудитын үнэлгээнд орсон гэрчилгээг хүлээн авсан.

Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл

- Говь ХК 2022 оны 3-р улирлын байдлаар Хөвсгөл болон Баянхонгор аймгуудад ХААИС-ийн эрдэмтэн багш нар болон малчидтай хамтран "Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл"-ийн ажлыг 100%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн.
- ХААИС-тай хамтран Хөвсгөл аймгийн Их-Уул сум болон Баянхонгор аймгийн Жинст сумд "Тогтвортой ноолуур, гурван талт төсөл"-ийн хүрээнд малчдад ноолуур бэлтгэлийн зохистой дадал эзэмшүүлэх сургалт хийх, төсөлд хамрагдсан сумдаас дээж аван ноолуурын чанарыг тодорхойлох шинжилгээ хийх, шаардлагатай багаж хэрэгслээр хангах, үржил селекцийн ажлыг хянах зэрэг ажлуудыг төлөвлөгөөний дагуу амжилттай хийж гүйцэтгэсэн.
- 2022.05.19-ний өдөр төслийн үйл ажиллагааг дэмжин Хөвсгөл аймгийн Их-Уул сумын малчид түүхт 90 жилийн ойгоо тохиолдуулан нийт 90 үржлийн шилмэл хээлтүүлэгч Говь ХК-д бэлэглэн, үйлдвэртэй танилцах аялал хийсэн.
- 2022 оны 9-р сард төслийн 2-р үеийн хаалтын арга хэмжээ зохион байгууллаа. Төслийн үр дүнд түүхий эдийн чанар сайжирч буй үзүүлэлт гарч байна.



Нэгдсэн удирдлагын тогтолцоо

- Говь ХК нь хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг тасралтгүй нэмэгдүүлэхийг чухалчлан авч үздэг бөгөөд энэхүү зорилгын хүрээнд Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг 2022 оны 3-р сараас эхлэн нэвтрүүлж эхэллээ. Төслийн ажил төлөвлөлтийн дагуу амжилттай явж байна.
- ISO45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болон ISO14001:2015 Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандартын хэрэгжүүлэлт бүрэн хийгдсэн бөгөөд 2022 оны 4 болон 7-р сард 2-р шатны аудитад орон, тэнцэж SGS баталгаажуулалтын байгууллагаас гэрчилгээ гардан авлаа.



Комплаенсын удирдлага

- 2022 оны 5-р сард Комплаенсын бодлого, зорилтуудыг батлан хэрэгжүүлж эхлэв.
- 2022 оны 6-р сард Бизнесийн ёс зүйг хөгжүүлэх зорилгоор Говь ХК нь Үнэт зүйлсээ шинэчлэн тодорхойлов.



- Нийт ажилтнуудад “Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлс, Уриа үг”-д нэгдэх, мэдлэг ойлголтоо нэгтгэх сургалт, уулзалтыг зохион байгуулав.
- ISO9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх төслийн хүрээнд хуулийн болон зохицуулалтын бүхий л шаардлагад нийцэж буй эсэхийг үнэлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- 2022 оны 8-р сард Компанийн Ёс зүйн кодыг шинэчлэн батлуулав. Ёс зүйн кодыг нийт ажилтнууддаа таниулах зорилгоор цахим сургалт зохион байгуулсан. Илүү хүртээмжтэй, ойлгомжтой байлгах зорилгоор анимэйшн байдлаар хийж байгаа.
- Компанийн үнэт зүйлс болон Ёс зүйн кодоо шинэчилсэнтэй холбоотой байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд удирдлагуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ТУЗ-ийн гишүүд болон Менежмент багийн удирдлагууд хамтарсан сургалт, workshop-г 9-р сард зохион байгуулсан.
- Шүгэл үлээх системийг хэрэгжүүлэхээр хөгжүүлэлт хийгдэж байгаа бөгөөд 2022 оны 10-р сард ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Эрсдэлийн удирдлага

- Компанийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээг хагас жил тутамд хийн, шаардлагатай эрсдэл удирдах үйл ажиллагааг шат дараалалтайгаар 100% бүрэн хэрэгжүүлж, байгууллагын хэмжээнд эрсдэлийг бууруулан ажиллаж байна.
- Улирал бүр эрсдэлийн мониторинг хийн, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнг үнэлэн удирдлагыг эрсдэлд суурилсан шаардлагатай мэдээллээр хангадаг.
- Байгууллагын бүтэц зохион байгуулалтын дагуу эрсдэлийн удирдлагын багийн томилгоог шинэчлэн батлав.
- 2022 оны 1-р улиралд байгууллагын эрсдэлийн түвшин 7.6 оноо /дунд/ байсан бол 3-р улирлын байдлаар 4.6 пунктээр буурч бага түвшин /3.0/ болсон байна.

Бизнесийн тасралтгүй үйл ажиллагаа

- Говь ХК-ийн бизнесийн тогтвортой байдлыг хангах зорилготой "Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны бодлого"-ын баримтжуулсан мэдээллийг Гүйцэтгэх захирлын тушаалаар 2022 оны 6-р сарын 7-ны өдөр шинээр батлав.
- Энэхүү бодлогын зорилго нь ирээдүйд үүсэж болох онцгой нөхцөл байдлаас үүдэн компанийн үйл ажиллагаа тасалдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хадгалах, нөхөн сэргээхэд оршино.
- Бодлогын хүрээнд компанийн хэмжээнд дараах дөрвөн чиглэлд хуваан үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад анхаарч ажиллана.

1. САНХҮҮ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2. ЗАХ ЗЭЭЛ,
ХЭРЭГЛЭГЧ

3. ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ПРОЦЕСС

4. ХҮНИЙ НӨӨЦ,
АЖИЛТАН

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД

Цусны донорын өдөрлөг

Говь ХК нь "Сайн дураараа цусаа хандивлах" Цусны донорын өдөрлөгийг "Цус сэлбэлт судлалын үндэсний төв"-тэй хамтран зохион байгуулж нийт 60 ажилтан сайн дураараа цусаа хандивлав.

Анхны тусламжийн мэдлэг олгох сургалт

Олон улсын "Эрүүл мэнд анхны тусламжийн сургалт"-ын стандартаар "Анхны тусламжийн мэдлэг олгох" 8 цагийн сургалтыг "Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг"-тэй хамтран нийт 175 ажилтныг хамруулж нэг жилийн хугацаатай ГЭРЧИЛГЭЭ олгов.

Гамшгаас хамгаалах дадлага, сургууль, бэлэн байдлын үзлэг

НОБГ, ХУДОБ-н албанаас зохион байгуулсан ХУД-н нутаг дэвсгэрт дээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй, нэгж байгууллагуудын дунд зохион байгуулсан "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг шалгалтад" 2022.09.29-ний өдөр байгууллагаа төлөөлж 10 ажилтан амжилттай оролцсон бөгөөд, 97%-тай "ДҮҮРЭН ХАНГАЛТТАЙ" дүгнэгдсэн.

БАЙГАЛЬ ОРЧИН

Эрчим хүч хэмнэлт

Говь ХК нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулахад онцгойлон анхаардаг бөгөөд компанид "Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл"-ийг байгуулан эрчим хүчний хэмнэлт, үр ашигтай хэрэглээг хэвшүүлэх дээр тогтмол санал санаачилга гарган ажилладаг. 2022 оны 4-р сард тус зөвлөлийг шинэчлэн байгуулж 2022-2024 онд хэрэгжүүлэх Эрчим хүч хэмнэлтийн хөтөлбөр, Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн ажиллах журмыг тус тус боловсруулсан.

Байгаль орчны гол үзүүлэлтүүд



Анхан шатны үйлдвэрийн угаах албаны угаах машины 4-р онгоцны усыг эргүүлэн 1-р онгоцонд дахин ашиглаж тус үйлдвэрийн жилийн нийт усны хэрэглээний 25% болох 2,130м3 ус хэмнэсэн байна.



Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Цэвэр, бохир усны дээж шинжилгээг улирал бүр, Агаар, хөрсний дээж шинжилгээг хагас жилд 1 удаа Байгаль орчны мэргэжлийн лабораторт шинжлүүлэхэд Стандартад нийцсэн үзүүлэлттэй гарч тогтмол хянаж ажиллаж байна.



2,802 ширхэг хаягдал баттерейг төвлөрүүлэн мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгснөөр 2,802м3 хөрс хордуулж, 22,416 тн гүний ус бохирдохоос сэргийлж чадсан.



1,058 ширхэг химийн бодисын хуванцар сав шилжүүлэн саармагжуулалт, хоргүйжилт хийж дахин боловсруулан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан ажилласан.



Гадаа талбайн 102 ширхэг улиас, 650 ширхэг хайлаас моддын хэлбэржүүлэн тайралт хийгдэж, 25 ширхэг голт бор мод тарьсан.



2021 оны онд нэгж бүтээгдэхүүнд ногдох эрчим хүчний хэрэглээ 9,450.6 төгрөг байсан бол 2022 оны 3-р улирлын байдлаар 3,189.8 төгрөг болж нэгж бүтээгдэхүүнд ногдох эрчим хүчний хэрэглээ 3 дахин буурсан үзүүлэлттэй байна. Мөн эрчим хүч хэмнэлтийн хүрээнд нийт 55 ш ухаалаг тоолуур суурилуулсан. Ийнхүү ухаалаг тоолуур суурилуулснаар цахилгаан эрчим хүчний зарцуулалтыг тогтмол хугацаанд нэгдсэн серверт цуглуулан хэрэглээгээ тогтмол хянах, цаашид эрчим хүчний өндөр хэрэглээтэй тоноглолуудад хэмнэлтийн үйл ажиллагаа хэрэгжүүлж эрчим хүчний бодит хэмнэлт бий болгоход оршино.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэв

МУ-ын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Говь ХК-ийн хамт олон нэгдэн “Байгаль орчны өдөрлөг” зохион байгуулсан. Энэхүү өдөрлөгөөр “Нэг ажилтан 18 мод” уриатай газар, үйлдвэр, нэгжүүдийн төлөөлөн болсон 70 гаруй ажилтнуудын оролцоотойгоор байгаль ээлтэй зөв дадал соёлын төлөвшүүлэх ажлыг амжилттай зохион байгуулав. Мөн ажилтан бүр хог хаягдлаа ангилан ялгаж, мод тарих арга аргачлалыг суралцав.



Булгийн эхийг тохижуулав

ХУД-ийн 14-р хороо буюу Өлзийт хорооны Зүүн бурхантын энгэр дэх булгийн эхийг тохижуулан, хамгаалалтын хайс хашаа хийж, хуучин байсан саравч сүүдрэвч зэргийг сэргээх ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөв.



Ходоодны рашаан гэгдэх бурхантын энгэрийн рашааны эх рүү мал орон бохирдуулж, оршин суугчид хэрэглэх боломжгүй байсныг ийнхүү тохижуулан оршин суугчдад хэрэглэх боломжийг бүрдүүлэхээс гадна мал ундаалах орчныг мөн давхар бүрдүүлсэн.



“Шар зураас” аянд нэгдэв

Сул хараатай иргэдийг дэмжих Нийгэмд үйлчилдэг ТББ-аас санаачлан Сул хараатай иргэдийг эрүүл аюулгүй орчинд амьдарч хөдөлмөр эрхлэх, сурч боловсрон мэдлэг эзэмших, барилга байгууламж болон гудамж талбайд саадгүй зорчиход дэмжлэг үзүүлэх зорилгоор "ШАР ЗУРААС" аяныг эхлүүлсэн. Учир нь сул хараатай иргэдэд шатны гишгүүрүүд нэгэн ижил өнгөөр харагддаг тул "ШАР ЗУРААС" аяныг хэрэгжүүлж шатны гишгүүрийн эхлэл ба төгсгөлийг хэвтээ шар өнгийн тусгаарлах зурвасаар тэмдэглэх ажлууд шат дараалалтайгаар явагдаж байна. Иймд Говь ХК энэхүү аяныг дэмжиж Улаанбаатар хотын иргэд ихээхэн зорчдог 106 бүсчлэлээс Ерөнхий сайд Амарын гудамжийг /329м урт/ сонгон түүнд холбогдох зардлыг санхүүжүүлэн аянд нэгдлээ.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн өдөрлөгт оролцов

ХУД-ийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй эцэг, эхчүүдийн уулзалт өдөрлөгт оролцож 100 хүүхдэд гарын бэлэг өгөв.



Оролцоо төсөлд хамтран оролцов

Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “ОРОЛЦОО” төслийн оролцогчдыг дадлагажуулах үйл ажиллагаанд ХУД, СХД, Төв аймагт нийт 4 удаагийн арга хэмжээнд оролцож, нийт 3 удаагийн үйлдвэрийн аяллыг зохион байгуулан, нийгмийн хариуцлагын хүрээнд ажлын байраар ханган хамтран ажиллав.



Good neighbors ОУТББ-тай хамтран

Гүүд Нэйборс ОУТББ-ын Монгол дахь суурин төлөөлөгч Говь ХК хамтран Монгол Улсын ирээдүй болсон хүүхэд залуусын сайн сайхны төлөө нийгмийн хариуцлагаа ухамсарлан “Сайн уу амьдрал минь” хөгжлийн хөтөлбөрийн оролцогчдод компанийн үйл ажиллагааг танилцуулан, ажилд орохыг урьж хамтран ажиллав.



Ирээдүйн баялаг бүтээгч хөтөлбөрийг зохион байгуулав

Говь ХК-ийн Сургалт хөгжил, идэвхжүүлэлтийн хэлтсээс их дээд сургуулиудын төгсөх ангийн оюутнуудад зориулж өөрийн эзэмшсэн мэргэжилдээ эзэн байж ирээдүйн баялаг бүтээгч болоход Говь ХК-ийн зүгээс хамтран ажиллах боломжийг олгох зорилготойгоор компанийн танилцуулга болон “Нийгмийн зөв хүн” буюу харилцаа хандлагын сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад ШУТИС болон Монгол Солонгосын Политехник Коллежийн 238 оюутан хамрагдав.



“Говийн багачууд” ажилтнуудын хүүхдийн цэцэрлэгтэй болов

Говь ХК-ийн удирдлагаас цэцэрлэгтэй болох шийдвэр гаргаж, хүүхдийн төлөө 3А гэж хэлье гэсэн нэг зорилго уриатайгаар хамтдаа нэгдэж 21 хоногийн дотор “Говийн багачууд” ажилтнуудын хүүхдийн цэцэрлэгээ компанийн түүхт 41 жилийн баяраараа амжилттай нээлээ.

Тус цэцэрлэг нь бага, дунд, ахлах, бэлтгэл гэсэн 4 бүлэгтэй, 120 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай, стандартын шаардлага хангасан цэцэрлэг болсон бөгөөд үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.



Team room-ийг тохижуулан нээв

Ажилтнууд болон хүүхдүүдэд нь зориулж TEAM ROOM нээсэн ба ажилтнууд чөлөөт хурал, уулзалт хийх болон бяцхан үрс ээж аавыгаа хүлээхдээ тав тухтай өрөөнд тоглох, кино үзэх, зураг зурах, хичээлээ хийх амрах зэрэг олон сонирхолтой зүйлийг хийх боломжтой өрөөг тохижуулсан.



Teenagers event зохион байгуулав

Хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд ажилтнуудынхаа хайртай үрсийг нь хөгжүүлэх, тэднийг ирээдүйн Говь ХК-ийн үнэт баялгийг бүтээсэн ажилтнууд болгох зорилгоор 8-р сард өсвөр насны 14-16 настай хүүхдүүдийн дунд “Teenagers event”-ийг зохион байгуулж ажилтнуудын 31 хүүхэд өөрийгөө хөгжүүлэх 6 цагийн сургалтад хамрагдсан.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Баатарсайхан - 2

Овог, нэр:

Албан тушаал: "Говь" ХК-ийн Гүйцэтгэх захирал

Албан тушаал : "... " Аудитын компанийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: М.Сэлэнгэ

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

Огноо: 2022.10.19



"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛОН
ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2022 оны 09 сарын 30

(мян.төгрөг)

	2022.09.30	2021.12.31
ХӨРӨНГӨ		
<i>Эргэлтийн хөрөнгө</i>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	8,397,850	4,389,479
Дансны ба бусад авлага	19,852,215	2,258,129
Урьдчилгаа төлбөр	2,713,773	3,127,757
Бараа материал	143,491,011	138,030,372
	174,454,849	147,805,737
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>		
Үндсэн хөрөнгө	139,645,554	145,404,533
Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	705,781	1,328,307
Хойшлогдсон татварын хөрөнгө	4,677,755	4,325,581
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	1,001,060	994,309
	146,030,150	152,052,730
Нийт хөрөнгийн дүн	320,484,998	299,858,467
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
<i>Богино хугацаат өр төлбөр</i>		
Дансны ба бусад өглөг	9,317,073	15,982,955
Гэрээний өр төлбөр	1,452,897	1,370,281
Орлогын албан татварын өглөг	65,570	111,894
Богино хугацаат түрээсийн өглөг	883,172	914,850
Богино хугацаат зээл	164,452,080	132,650,889
	176,170,792	151,030,870
<i>Урт хугацаат өр төлбөр</i>		
Урт хугацаат түрээсийн өглөг	16,778	672,587
Урт хугацаат зээл	100,803,920	93,407,780
Бусад урт хугацаат өглөг	29,984,049	25,622,107
	130,804,747	119,702,474
Нийт өр төлбөрийн дүн	306,975,539	270,733,344
<i>Эзэмшигчдийн өмч</i>		
Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл	48,870,401	48,870,401
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(1,565,331)	561,878
Хуримтлагдсан алдагдал	(34,575,723)	(21,087,268)
	13,509,460	29,125,123
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	320,484,998	299,858,467

(мян.төгрөг)

	2022.09.30	2021.12.31
Борлуулалтын орлого	104,800,103	144,344,329
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(55,826,393)	(85,543,487)
Нийт ашиг	48,973,710	58,800,842
Санхүүгийн ба бусад орлого	722,257	963,425
Бусад олз (гарз)	(5,599,270)	2,913,718
Санхүүгийн зардал	(18,447,413)	(25,474,286)
Борлуулалт ба маркетингийн зардал	(29,965,330)	(60,568,067)
Ерөнхий ба удирдлагын зардал	(9,486,424)	(14,636,714)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	-	(110,920)
Татварын өмнөх алдагдал	(13,802,471)	(38,112,002)
Орлогын татварын өгөөж (зардал)	314,016	165,974
Тайлант жилийн цэвэр алдагдал	(13,488,455)	(37,946,028)
Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:		
Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	2,127,208	1,923,910
Бусад дэлгэрэнгүй алдагдал	2,127,208	1,923,910
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	(11,361,246)	(36,022,118)

(мян.төгрөг)

	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт
2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	780,113	48,974,836	(1,362,032)	16,858,760	65,251,677
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(37,946,028)	(37,946,028)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	(104,435)	1,923,910	-	1,819,475
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал		(104,435)	1,923,910	(37,946,028)	(36,126,554)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	780,113	48,870,401	561,878	(21,087,268)	29,125,123
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(13,488,455)	(13,488,455)
Бусад дэлгэрэнгүй алдагдал			(2,127,208)	-	(2,127,208)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	-	-	(2,127,208)	(13,488,455)	(15,615,663)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
2022 оны 09 сарын 30-ний үлдэгдэл	780,113	48,870,401	(1,565,331)	(34,575,723)	13,509,460

(мян.төгрөг)

	2022.09.30	2021.12.31
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(18,529,575)	19,987,525
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(2,447,243)	(212,013)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	24,807,686	(30,108,651)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,830,869	(10,333,139)
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	177,502	1,923,873
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,389,479	12,798,745
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,397,850	4,389,479



MONGOLIAN CASHMERE
ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
ЭРСДЭЛ АУДИТЫН ХОРООНЫ
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Г 2022 оны 3-р улирлын санхүүгийн
тайланг дүгнэх тухай Г

Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Эрсдэл, аудитын хорооны хурлаас **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн 2022 оны 3-р улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь үнэн зөв тайлагнагдсан болохыг баталсугай.
2. 3-р улирлын тайланг холбогдох журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж-д хүргүүлэн олон нийтэд тайлагнан ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

Говь ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх

Эрсдэл, аудитын хорооны дарга

Гишүүд



М.БАЯР

Д.ХУЛАН

А.ЖАРГАЛМАА